

МОНГОЛЧУУД БА ЛАЛЫН ЕРТӨНЦИЙН
ХӨГЖЛИЙН АСУУДАЛД

Д. Баярсайхан*

Монголчууд бидний түүхээрээ бахархах асуудалтай холбогдуулан энэхүү өгүүллийг тэрлэлээ. Монголчууд дундад зуунд дэлхийн түүхийг өөрчилсний тод жишээг лалын ертөнцөөс харж болох юм. Иймд тэр үеийн монголчуудын нэг хэсэг болсон Ил-хаад лалын ертөнцийн түүхэн бичлэг, аялал жуулчлал, соёл урлагт хэрхэн нөлөөлсөн талаар товч өгүүлэхийг зорилоо.

Юуны өмнө Израйлын Их сургуулийн монголын түүх судлаач Микал Бираны бичсэн *Чингис хаан* хэмээх ном уг сэдвийг сэдрээсэн болохыг дурдахад таатай байна. Тэр бээр сүүлийн үед нийтлэгдсэн Евроазийн түүхнээ монголчуудын оруулсан хувь нэмрийг олон талаас нь судалж буйдаа тулгуурлан ислам буюу лалын ертөнцөд Чингис хаан хэмээх энэ агуу хүн ямар ул мөр үлдээсэн тухай судалгааны бүтээлээ нийтлүүлсэн юм.

Монголын эзэнт гүрний түүхийг үзэхэд, бахархах зүйл гэхээсээ илүүтэй эвдэж сүйтгэсэн, булааж эзэлсэн, алж талж хүйс тэмтэрсэн, дээрэм тонуул хийсэн, хүн төрөлхтний соёл иргэншлийг олон зуун жилээр ухраасан гэдэг бараг нэр томьёо маягтай болсон зүйл эрхгүй олон гардаг. Иймэрхүү бодолтой судлаачид цөөнгүй байж, тэр үнэлэмжээрээ монголчуудын аян дайныг мэргэжлийн хүрээнд ч тодорхойлдог байв. Ялангуяа Чингис хаан болон түүний үр удмыг “хүн төрөлхтний хар тахал” хэмээн нэрлэж байсан нь тун саяхан.

Өнгөрсөн XIX зууны сүүл болон XX зууны эхээр Английн эрдэмтэн Е. Броуне (E. Browne) лалын ертөнцийн талаарх судалгаандаа Монголын байлдан дагуулал нь дэлхийн түүхнээ тохиосон хүн төрөлхтний хамгийн аймшигт гамшиг хэмээн үзсэн боловч үүнийг лалын орнуудад нийтэд нь хамруулж болохгүй тухай анхлан бичиж эхэлсэн билээ. Бас Англи судлаач Бернард Левис (Bernard Lewis) дэлхийн нэгдүгээр дайны дараахан еврейчүүдийг хоморголон устгасан түүхийг судлан бичихдээ Монголчуудын учруулсан сүйрэл нь Ираны хувьд үнэн боловч Иракд огт нөлөөлөөгүй тухай шинэ судалгааг гаргаж ирсэн. Энэ санааг Персийн түүх судлаач Давид Морган үргэлжлүүлэн, Монголын байлдан дагууллын учруулсан

* Бонны Их Сургууль

сүйрлийн хэмжээ барагдашгүй хэмээн тодорхойлсон авч тухайн сэдвийн хүрээнд шинэ уур амьсгал оруулж ирсэн байна.¹

Дэлхий ертөнц, шинжлэх ухаан хөгжихийн хэрээр Монголчуудын аян дайн хийгээд XIII-XIV зууны монголчуудын түүхийг шинээр эргэн харах сайхан боломж нээгдэж байгаад хувьдаа ихэд олзуурхаж байна. Оросын эрдэмтэн В. Бартольд анх Монголын байлдан дагууллын талаар бодит судалгаа гаргаж ирсэн. Түүний Туркестаны жишээн дээр бичсэн Монголын байлдан дагууллын судалгааг гүйцэх бүтээл одоо хэр нь гарч ирээгүй байна.² Францын эрдэмтэд Жан Аубин (Jean Aubin) болон Денис Айгл (Denise Aigle) нар лалын ертөнцийн Монголын байлдан дагууллын талаарх сурвалжийн мэдээг эргэн харах санааг дэвшүүлжээ.³ Үүний нэг жишээ болох алагдсан хүн амын тооны талаарх санааг доор өгүүлсүү.

Дээр хэлсэнчлэн, сүүлийн үед Монголын эзэнт гүрний түүхтэй холбоотой олон талт судалгааны ажил хэвлэгдэн нийтлэгдэх боллоо. Америкийн эрдэмтэн Томас Аллсэн (Thomas Allsen), Тимоти Мэй (Timothy May), Жүдит Колбас (Judith Kolbas), Израйлын Реувен Амитай (Reuven Amitai), Микал Биран (Michal Biran) зэрэг олон судлаачдын бичсэн ном, нийтлэлд энэ дэлхийн түүхэнд төдийгүй цаашлаад дэлхийн хөгжилд монголчуудын оруулсан хувь нэмэр, шууд буюу шууд бусаар нөлөөлсөн ач холбогдлыг дэлгэн гаргаж байна.

Миний бие Иран, Ирак, Кавказ, бага Ази, Сири болон Палестины нутгаар суурьшиж байсан Монголчуудын түүх буюу Ил-хаадын түүхийг судалж байхад лалын түүх судлах хэрэгцээ гардаг байлаа. Ил-хаант улс нь Монголын эзэнт гүрний нэгэн хэсэг бөгөөд 1256-1335 он хүртэл Чингис хааны хүү Тулуйн үр ач нарын мэдэлд байсан улс юм. Тулуйн хүү Хүлэгү хаан өөрийн ах Мөнхийн зарлигаар анх Иранд ирж суурьшсанаар энэ нутгийн Монголын үе эхэлдэг. Ил-хаант улсын түүхнээ Хүлэгү (1256-1265), Абага (1265-1282), Төгөлдөр (1282-1284), Аргун (1284-1291), Гайхалт (1291-1295), Байду (1295), Газан \Хайсан\ (1295-1304), Өлзийт (1304-1316), Абу Саид (1316-1335) нарын Монгол хаад төр барин Иранд төвлөрөн сууж байжээ. Эдгээр Монгол хаадыг Ил-хаад буюу “харьяат хаад” хэмээдэг учир нь тэд Тулуйн өөр нэгэн ач хүү Их хаан Хубилайд харьяалагдаж байснаас үүджээ.

Ил-хаадын талаар товчхон дурдахад, Хүлэгү хаан Дундад болон Ойрх Дорнодын хоёр их хүчийг устгаж дээр хэлсэнчлэн, Монголын үеийг тэрхүү нутагт эхлүүлсэн хүн юм. Тэр бээр тухайн бүс нутагт улс төрийн аллага хийдэг буюу эсрэг талынхаа тэргүүлэгчийг хутгалан алдаг “ассасин” нэрээр алдаршсан Исмаилынхныг устгаж дараагаар нь лалын ертөнцийн цөм болох тухайн бүс нутагт 500 гаруй жил ноёрхож байсан Аббасын удмын Калифыг устгаснаар дундад дорнодын түүхийн цоо шинэ үе эхэлсэнтэй хамт лалынханы монголчуудыг жигших зэвүүцлийн эхлэл тавигджээ. Энэ тухай доор тодорхой өгүүлэх болно.

Аргун болон Абага хаад түүхнээ олон талт дипломат харилцааг хөгжүүлсэн гавьяат хаад юм. Тэд өвлөж авсан нутаг бэлчээрийн маргаанаас үүдсэн Алтан Орд, Цагаадайн улстай хийсэн том жижиг дайнд татагдан орж байснаас гадна, лалынхны эсрэг Христийн ариун дайн буюу

¹ Melville, 1997, *The Impact of the Mongol invasions on Iran, Iraq and Central Asia; A Revaluation*, The Indo-Mongolian lecture at the New York University, March 12, 1997.

² Barthold, V., *Turkestan Down to the Mongol Invasion*, ts. by H. A. R. Gibb, second edn. London: E. J. W. Gibb Memorial Trust, 1958; fourth edn. 1977.

³ Aigle, D. *L'Iran face à la Domination Mongole*, Tehran: Institut Français de Recherche en Iran, 1997.

Загалмайтны аян дайнд Монголчуудын хүчийг хавсаргах яриа хэлэлцээрийг Европын хаад хийгээд Ромын Пап ламтай хийж, элч мордуулж, захиа илгээж байжээ.

Анхны Ил-хаадын эхлүүлсэн улс төр, шашин, соёл, эдийн засгийн бодлогыг залгамжлагч хаад улам бүр хөгжүүлсээр, 1295 онд хаан ширээнээ заларсан Газан буюу Хайсан хааны үед Иранд төвлөрч байсан монголчууд лалын шашинд орсон түүхтэй. Ил-хаадын түүх тун сонирхолтой бөгөөд тус бүрдээ хүүрнэн өгүүлэх их зүйлтэй боловч тэдний лалын шашинтай хэрхэн харьцаж, лалын ертөнцөд хэрхэн нөлөөлсөн нь илүүтэй сонин байх болов уу.

Юуны өмнө XIII зууны Персийн түүхчдийн бичсэн сурвалжаас үзэхэд, Монголын аян дайнд сүйрсэн орон нутаг, хүн ам, мал ахуйг өгүүлшгүй аймшигтайгаар дүрсэлсэн байдаг. Тэгэхлээр, Персийн түүхчдэд Монголын аян дайн, тухайн нутгийн сүйрлийг зүйрлүүлэх өөр аян дайн байсан уу гэдэг асуулт тавья. Үүнд дүйцүүлж болох ганц нь VII-VIII зууны Ойрх дорнодын арабын байлдан дагуулал байж болох юм. Энэ хоёр аян дайныг жишиж үзвэл, арабын байлдан дагуулал монголынхоос тун бага газар нутгийг хамарсан, гэнэт биш аажмаар явагдсан, шашны тархалт байсан учраас нийтийг алж талах нь бага байжээ. Иймд, монголчуудын байлдан дагуулал лалын ертөнцөд урьд өмнө үзэж байгаагүй их нүсэр дайрал болсон учир лалын түүхчдийн бичиж үлдээсэн бүхэн тэдний ертөнц цочирдсоны нэгэн жишээ билээ.

Лалын түүхчдийн бичсэнээр, Самарканд, Бухар, Херат болон Нишапурын хүн амыг Монголчууд хоморголон устгасан гэдэг. XIII зууны Арабын түүхч Ибн ал-Атир, Насави, Персийн түүхч Жувайни, Жужжани нарын үлдээсэн мэдээгээр 1220 оны 3-р сард Чингис хаан хүү Цагаадайг Хорезмын Утрар хотод үлдээгээд өөрөө Бухарын зүг хөдөлжээ. Түүнийг нэгэн сурвалжийн мэдээгээр 12000 цэрэгтэй мордсон гэсэн бол, өөр нэг сурвалжид 20000, бүр 30000 цэрэгтэй мордсон ч гэсэн нь бий. Дагуул цэргийн тооны маргааныг орхиод, Бухар хот, дараагаар Самарканд хотын хүн ам хүйгээрээ устгагдсан хэмээх асуудлыг авч үзвэл, тухайн үед Бухар, Самарканд хотынхон төвдөө цугларан Монголчуудад бууж өгсөн байдаг. Бууж өгсөн хүний тоо тодорхойгүй бол, хотын хамгаалалтын цэргийн тоо бас л их зөрөөтэй, Жувайни 110000 цэрэг, Жужжани 60000, Ибн ал-Атир 50000, Насави 40000 гэжээ. Тэр үеийн хотын дундаж хүн амын тоог судалбал, 100000 өрхтэй буюу 500000 хүнтэй хот ховор байсныг бодолцоход, зөвхөн 1220 онд Трансохиан буюу Бухар Самарканд хотын 1,2 сая, Мерв хотын 1,3 сая, Нишапурын 1,7 сая, 1222 онд Хератын 2,4 сая хүн ам алагдсан гэх тоо үнэхээр тэр үеийн түүхчид цочирдсондоо бичсэн тоо болохоос өөр нотлох зүйлгүй билээ. Хотын хамгаалалтын цэргийн тоо 400 хүрэхтэй үгүйтэй байсныг бас дурдах хэрэгтэй.⁴

Лалын ертөнцөд Монголын аян дайн хийгээд Чингис болон түүний хойчсын тухай мэдээлэл нь сүйрлээс өөр зүйлгүй хэмээн зарим судлаачид үздэг. Гэтэл түүх гэдэг ухагдахуун хэзээ ч сайн, муу гэж шууд тодорхойлогдох амар зүйл биш. Миний өгүүлж буй түүх ч үүний адилаар нэлээд ээдрээтэй байсан аж. Хамгийн наад захын жишээ хэлэхэд, монголчууд лалын ертөнцөөс XIV зуунд арчигдсан гэж үздэг боловч Чингисийн үр удам лалын Баруун азийн тал нутаг, Дундад ази, Хойд Энэтхэгийг XVIII-XIX зуун хүртэл захирч байсан билээ.

Лалын ертөнцтэй зүйрлүүлэх соёл иргэншил Монголчууд бүтээгээгүй хэмээдэг атал Монголын үе хэмээн нэрлэгдэх соёлын их өвийг лалын байтугай, дэлхийн хэмжээнд

⁴ Melville, 1997, *The Impact of the Mongol invasions on Iran, Iraq and Central Asia; A Revaluation*, The Indo-Mongolian lecture at the New York University, March 12, 1997.

үлдээжээ. Тэрхүү өв уламжлал нь монголчуудын язгуурын соёлоос илүүтэйгээр эзэнт гүрний хэмжээнд байсан олон соёлын тогтолцооны нийлбэрийг бий болгосонд оршдог юм.

Жишээлбэл, Чингис хааны болон түүний үр садыг бичиг үсэг мэддэггүй бүдүүлэг хүмүүс байсан мэтээр бичдэг. Гэтэл түүхэн сурвалжуудад монгол, араб, перс, хятад алинд ч тэдний бичиг үсэгт тайлагдсан болон тайлагдаагүйг батлах нотолгоо байхгүй. Чингис хаан хийгээд Ил-хаадыг оролцуулсан түүний үр сад би ниг соёлыг дээдэлдэг байсан, тиймдээ ч Монголын эзэнт гүрний хэмжээнд олон хэл, олон бичиг үсгийг чөлөөтэй хөгжүүлж байсан байна. Үүний нэгэн илэрхийлэл бол 1360 онд лалын Йеменд *Зургаан хэлний толь бичиг* гарсан явдал юм.⁵ Энэхүү номыг лалынхан *Хаадын толь бичиг* хэмээдэг ба Расулын удмын ал-Малик ал-Афдал Аббас Али (1363-1377) эрхлэн гаргажээ. Тус толийн араб, перс, турк, монгол, грек, армян зургаан хэл нь Монголын Ил-хаадын эзэмшил нутгийн хамгийн чухал зургаан хэл байж, Монголын үеийн улс төр, худалдаа, соёлын гол хэл байсны тод жишээ болж байна. Толь бичигт газар шим ертөнц, хүний бие эрхтний бүтэц, цаг хугацаа, орон зай, он тоолол, улирал, газар зүй, нэхмэл сүлжмэл, бөс бараа, ургамал, амьтан, хоол хүнс, өнгө будаг, зэр зэвсэг, тооны ухаан зэргийг агуулсан өргөн хүрээний үгс, нэр томъёог зургаан хэлнээ буулгасан байжээ.

Уг толийг Монголын Ил-хаадын үе Иранд төгсгөл болж байх үед бичиж эмхтгэсэн боловч Монголын эзэнт гүрэнд олон хэлний толь бичгийн хэрэгцээ их байсан хийгээд бичиг үсгийн арвин өв уламжлалын нэг л жишээ нь энэ юм. Монголчууд бичгийн болон ярианы аль ч хэлбэрээр, олон хэл мэддэг хүнийг ихэд хүндэлдэг байсан агаад гадаад хэл мэддэг нэгэндээ эрх ямба хүртэл олгож байжээ. Түүнчлэн, олон хэлний сургалт, орчуулгын товчоо ажиллуулж байсны нотолгоо Иран, Хятад, Армян, Солонгос, Хойд Энэтхэг, Египт, Крымд олдсон олон хэлний нэр томъёоны жагсаалтаас харагдаж байна.⁶

Түүх бичлэгийн хувьд, Ил-хаадын оруулсан хувь нэмэр мөн адил зүйрлүүлшгүй билээ. Персийн түүхч Рашид ал-Дин Газан хааны зарлигаар Монголчуудын түүх бичиж эхлээд Өлзийт хааны үед түүнийгээ тэлэх зарлигаар, тухайн үед дэлхийд танигдан мэдэгдэж байсан улс үндэстнүүдийн түүх болгон бичжээ. Чингис хааны өвөг дээдсээс эхлэн Чингис хааны үе, түүний хөвгүүд ач нарын үе, Хубилайн залгамжлагч болох Төмөр Өлзийт хааны үе хүртэлх монголчуудын түүхээс гадна Хятад, Энэтхэгийн түүхийг хамарч, Еврейчүүд, Франкууд болон лалын ертөнцийн түүхийг газар зүй, угсаа гарлын судалгаатай нь хамт бичсэн ховор бүтээл туурвижээ.

Рашид ал-Дин еврей гаралтай бөгөөд 1290 оноос эхлэн 1318 онд нас эцэслэх хүртлээ Монгол Ил-хаадын ордонд зөвлөхийн үүрэгтэй *визирь* хэргэмтэй хүн байжээ. Хүн төрөлхтний түүхнээ ижил нь байхгүй тийм түүхийг энэ хүн ганцаараа хэрхэн бичих билээ. Хубилай хаанаас Иранд илгээсэн бие төлөөлөгч ба Монгол төрийн сайд Болад (Chinksank) нь тухайн үедээ монголчуудын нууц хэмээх түүхэн сурвалж болох *Монголын нууц товчоон*, *Алтан дэвтэр*, *Хар хорумын их судар*, *Хубилай хааны Цагаан түүх* болон аман түүхийг Рашид ал-Динд олгосны ачаар *Судрын чуулган* хэмээх энэхүү алдарт түүх бичигдсэн билээ.⁷ Энэ түүх

⁵ *The King's Dictionary: the Rasulid Hexaglot-fourteenth century vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian, and Mongol* / translated by Tibor Halasi-Kun ... [et al.]; with introductory essays by Peter B. Golden and Thomas T. Allsen; edited with notes and commentary by Peter B. Golden.

⁶ Biran, M., *Chinggis Khan*, Oneworld, 2007: 93.

⁷ Dalai, 1992:9; Bira, 2001:399; Klaus Sagaster, 1976.

тэр үедээ ч, дараа дараагийн үед ч дахин гараагүй түүхэн бичлэг бөгөөд бидний үед уламжлан ирээгүй монгол хэд хэдэн сурвалжийн мэдээн дээр тулгуурлан бичигдсэн нь зохиолын нэрээс илт байна. Би хувьдаа үүнийг бидний монголчуудын бичиг үсгийн соёлтой холбоотой нэгэн их маргааныг таслах сайхан жишээ гэж боддог. Учир нь, *Монголын нууц товчоо*ноос өөр бичиг үсгийн дурсгал, эртний соёлтой байсныг маань нотлох нэг баримт гэж үзэж болно.

Өнөө цагт монголчууд даяарчлалыг эхлүүлсэн гэж хэлж ярих дуртай болжээ. Хэдий ор үндэсгүй зүйл биш боловч тэрхүү даяарчлал чухамдаа яаж илэрч байсан бэ гэдгийг нарийн судалгааны үүднээс авч үзэх нь зүйтэй. Лалын жишээн дээр гэхэд, Морокко гаралтай дундад зууны алдарт түүхч Ибн Баттута (1304-1368) 1324 онд Мекка руу гороо хийхээр гэрээсэ гарчээ. Энэ нь түүний 30 жилийн аяллын эх болж тухайн үеийн хүний мэдэж байсан бүхий л газар орноор аялж, Чингис хааны үр ач нарын эзэмшил болох Юань гүрэн, Ил-хаадын улс, Алтан орд, Цагаадайн ханлигт бүгдэд нь очиж үзсэн бөгөөд Дундад дорнод, Кипчакийн тал, Афганистан, Дундад Ази, Энэтхэг, Хятад, Зүүн-өмнөд Ази, Өмнөд Европ төдийгүй Африкт хүртэл очсон байжээ. Үүнээс үзэхэд, бидний гайхлыг төрүүлсэн Марко Поло болон бусад аялагчдаас хавьгүй их газар нутгийг Ибн Баттута туулсан байна. Чухамхүү ийм аялал нь Чингисийн байгуулсан тэрхүү уудам эзэнт гүрний хүрээний улс орон даяарчлагдсан байсны улмаас боломжтой болсон гэж дүгнэж болно. Ибн Баттута явсан газар нутгийнхаа талаар тэмдэглэл хөтөлж өөрийн сонирхож байсан хаад, гэгээнтнүүд, тэдний шарил бунхан болон эмэгтэйчүүд, хоолны талаар нарийн мэдээлэл үлдээжээ.⁸

Монголчуудын үед соёлын огтолцлол дээр лалын ертөнцийн уран зураг, номын чимэглэлийн урлаг, бөс бараа даавуу, анагаах ухаан, одон орон судлал, математик, дайн тулааны зэр зэвсэг, шинжлэх ухаан ихэд хөгжжээ. Уран барилгын маш тодорхой жишээ бол Ираны Султанияа хот дахь Өлзийт хааны бунхан юм.

Дотоод голчоороо 25 м, найман талт энэхүү барилга нь Ил-хаадын төдийгүй лалын ертөнцөд урд өмнө огт байгаагүй хийгээд дахин давтагдаагүй тийм барилга юм. Учир нь Өлзийт хааны энэ бунхан лалын мөргөлийн өргөө буюу масчид сүм мөртөө лалын сүм хийдийн тогтсон хэв хэлбэрт баригдаагүй, уламжлалт дэг ёсоор хоёр бөмбөгөр оройн нэг нь нөгөөгөөс нам байдаг атал хоёул ижил түвшинд очсон төдийгүй уран барилгын шийдлээрээ тухайн үед шинэ технологи нэвтрүүлсэн барилга болжээ.⁹ Энэхүү өвөрмөц шийдлийн гол учир тухайн үед монголчуудаар дамжиж ирсэн Монголын эзэнт гүрний олон язгуурын нийлмэл соёлын хөгжилд байгаа юм. Өлзийт хааны энэ бунхан бүтэц, дотоод чимэглэл, өнгө будгаараа XIV зууны лалын нэг хэв жаягтаа хэт баригдсан уран барилгыг цоо шинэ түвшинд хүргэсэн нэгэн гайхамшиг юм. Харамсалтай нь түүхэнд Монголын эзэнт гүрний гэхээсээ, Ираны уран барилгын сор хэмээн үлджээ.

Энэ мэт олон сайхан жишээ сурвалжуудад байдаг бөгөөд миний анхаарал татсан нэгэн зүйл бол уран зургийн хөгжил юм. Монголоос өмнөх үеийн лалын ертөнцөд Багдадад төвлөрсөн Византины нөлөө бүхий урлаг, Ираны орон нутгаар лалын уламжлалт уран зургийн чиглэл голлож байсан бол Ил-хаадын үеэс эхлэн Персийн уран зураг хөгжиж эхэлсэн гэдгийг урлаг судлаачид нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг билээ.¹⁰ Тодруулбал, Ил-хаад болон Юань гүрний нягт харилцааны дүнд, ялангуяа Хятадаас хангадаг байсан цаасны нөлөөгөөр

⁸ Ibn Battutah, *The Travels of Ibn Battutah*, tr. by Hamilton Gibb, Tim Mackintosh-Smith (ed.), London: Picador, 2003.

⁹ O. Grabar, in Boyle, J.A., *The Cambridge History of Iran*, v. 5, 1968:635-638.

¹⁰ *Ibid*, 648.

Персийн уран зураг хөгжлийн нэгэн шат ахисан түвшинд очиж, байгалийн уран зураг, хээ угалз, бэлгэдэл болон сэдэвт уран зураг түлхүү хөгжлөө олжээ. Энэ хөгжил дэвшил Персийн номын чимэглэлийн урлаг буюу судар бичгээ зургаар гоёх, бичвэрийн үндсэн үйл явдалд нийцсэн зураг чимэглэл өргөнөөр ашиглахад хүргэжээ. Энэ нь лалын уран сайхны ертөнцийн хөгжлийн чиг хандлагыг залж, улам тархсаар доголон Төмөр хааны үед лалын урлагийн стандарт буюу хэв жишиг болсон байна.¹¹ Бидний мэдэх Рашид ал-Дины *Судрын чуулган*, Ираны үе үеийн баатарлаг тууль болох *Шах намэ*, үлгэр домгийн дээж болсон *Халила ба Димна* зэрэг нь Персийн тухайн үеийн ном судрын чимэглэлийн урлаг хийгээд дэлхийн урлагийн ховор нандин бүтээлүүдэд одоо хэр тооцогдож байна.

Бидний монголчуудыг кино болон зурагт дүрслэхдээ зэрлэг араатан адил түүхий махны цусыг нь асгаруулан зулгааж байгаа бүдүүлгээр буулгадаг. Гэтэл дундад зууны монголчууд Иран болон Хятадын хоолны соёлыг баяжуулахын дээр, идээний аль сайхныг идэж, оорсдийн сонирхолд нийцүүлэн монгол хоолны амт гаргахыг даалгаж байжээ. Үүний тод жишээг Юань улсын хаадын мэдэлд байсан *Yin-shan cheng-yao* хэмээх хоолны жорын нэгэн номноос харж болох юм. Энэ номыг хааны ордны хоол хүнсний эрүүл ахуйг хариуцаж байсан Ну Szu-hui хэмээх нэгэн эмч 1330 онд эмхэтгэсэн тул Хятад хоолны жор хэмээн одоог болтол эндүүрч байжээ. Гэтэл Жорж Лейны (George Lane) үзэж байгаагаар энэ бол Монгол хоолны жороос бүрдсэн ном агаад Ну Szu-hui нь өөрөө Түрэг гаралтай хүн байжээ. Хэрэв энэ ном анхлан Монгол эсвэл Уйгар хэлээр бичигдэж хожим нь Хятад хэлнээ хөрвүүлэгдээгүй юм бол Хятад хэл сайн сурсан гадны хүний бүтээл байх үндэслэлтэй болно. Учир нь тухайн номонд орсон бүх жорыг судлан үзвээс хятад, түрэг, перс болон лалын ертөнцийн хоолны найрлагыг Монгол хоолны амт, таашаалд нийцүүлэн гаргасан онцлогтой юмсанж. Иймээс *Yin-shan cheng-yao* нь монгол хоолны ном болохыг Лейн онцолсон байна.¹²

Монгол хоолны соёл Арабын хоолны жоронд нөлөөлсөн жишээг дундад зууны *Safarjaliya* хэмээх нэгэн жороос харж болох юм. Энэ нь хонины сүүл хэрхэн чанах тухай жор юм. Монгол шөл гаргах жор Палестин, Анатоли болон Газрын дундах тэнгисийн орнуудад ихэд дэлгэрсэн байжээ.¹³

Тэр байтугай хоолны хольц нь анагаах буюу эмчилгээний үүднээс байна уу, таашаал авах үүднээс байна уу, аль эсвэл хордуулах үүднээс хийсэн зоог уу гэдгээ хүртэл нарийн мэдэрч байсан байна.¹⁴ Энэ нь илүүтэйгээр орд харшийн амьдралтай холбоотой байсан бол жирийн ард ч алсын аян дайнд зохицох хоол хүнсээ сайтар бэлтгэж урт удаан хугацаанд өл даах тийм чанарын хүнсээ хийгээд, шарх болон гэмтлээ анагаах өвс ургамлаа хатаан авч байснаас үүтгэн үзвэл, хоолны нарийн соёл монголчуудад эртнээс байсаар иржээ. Тухайн үед гадны жуулчид өөрсөдтөй нь харьцуулахад мах илүүтэй идэж байсан монголчууд хачирхалтай байсан нь бас ортой. Гэхдээ Чингис хаан болон түүний үр ач нарын байгуулсан тэр их өргөн

¹¹ Biran, M., *Chinggis Khan*, Oneworld, 2007:90.

¹² Lane, G., *Daily life in the Mongol Empire*, Greenwood Press, 2006:167-173. Buell, P., "Mongol Empire and Turkicization: The Evidence of Food and Foodways" in the *The Mongol Empire and its Legacy*, eds. R.Amitai-Preiss, and D. Morgan, Brill, 1997:205-222.

¹³ Монголын эзэнт гүрний хоол хүнсний талаар Lane, G., *Daily life in the Mongol Empire*, Greenwood Press, 2006:167-179 –ээс үзнэ үү.

¹⁴ Энэ болон бусад ахуйн нөлөөний талаар Thomas Allsen, *Culture and Conquest in Mongol Eurasia*, Cambridge: Cambridge University Press, 2001-ээс үзнэ үү.

уудам гүрний соёл ганц Монголын язгуур соёл байхаасаа халин, нүүдлийн болон суурин улс иргэдийн сайн сайхан, чанартай чамин бүхний найрал болон дэлгэрсэн гэдгийг онцлон дурдъя.

Шашин шүтлэгийн хувьд, Иран, Дундад Азид байсан монголчууд лалын шашинд орохдоо тэрхүү шашныг дэлгэрүүлэх явцыг тэлсэн болно. Тэд шууд болон шууд бус замаар Зүүн Европын тал нутаг, Хятад, Энэтхэг, Зүүн-өмнөд Ази, алслагд Африкт ислам дэлгэрэхэд нөлөөлсөн байна. Бусад газарт хэрхэн яаж нөлөөлснийг дүгнэж мэдэхгүйн улмаас Ил-хаадын улсын жишээн дээр авч үзвэл, нэгд, дагаар орсон перс, селжүк, араб албатуудыг засаглан захирахдаа монголчууд зонхи олонхын шашныг авсан, хоёрт, тухайн бүс нутгийн шашин төрийн тэргүүлэгч Калифыг мөхөөснөөр тэр нутгийн шашнаар дамжуулан төрийн удирдлагыг гартаа авах ухаан Ил-хаадад байсан болов уу. Перс болон Араб сурвалжийн мэдээгээр Ил-хаад лалын ёс, дэглэм, зан үйлийг тухайн үедээ тун өнгөц хэлбэрээр даган мөрддөг байсан ба махаа идэж айргаа уусаар байсан бололтой.¹⁵ Хэдийгээр Ил-хаад исламд орсон боловч өвөг эцэг Чингис хааныхаа бусад шашин шүтлэгийг хүндэтгэн дэмжих ухаанаар улс гүрнээ удирдан жолоодсоор иржээ. Ил-хаадын үед баригдсан христийн сүм, лалын масчид сүм, бүддийн хийдийн тоо их байсныг өнөөгийн археологийн малтлагаар хаа сайгүй гарч байгаа олдвороос дүгнэж болно.

Хүн төрөлхтний түүхнээ шашин, хэл, соёлын хувьд Монголын эзэнт гүрэнтэй зүйрлүүлэх тийм эрин байгаагүй хэмээн эрдэмтэн Биран онцлон дүгнэсэн байдаг.¹⁶ Түүний энэхүү дүгнэлт бидний монголчууд хэл, соёл, түүхээ дээдлэн, түүгээрээ зөв бахархаж байхыг өгүүлсэн биз ээ.

Номзүй

- Aigle, D. *L'Iran face à la Domination Mongole*, Tehran: Institut Français de Recherche en Iran, 1997.
- Amitai, R., *Studies in the History of the Ilkhanate*, Aldershot: Ashgate/Variorum, 2007.
- Mongols and Mamluks. The Mamluk-Ilkhanid War, 1260-1281*, Cambridge: Cambridge University Press, 2004.
- Amitai, R. and Biran, M. (eds.), *Mongols, Turks and others: Eurasian Nomads and the Sedentary World*, Leiden: Brill, 2005.
- Allsen, T., *The Royal Hunt in Eurasian History*, Philadelphia: Penn, University of Pennsylvania Press, 2006.
- Culture and Conquest in Mongol Eurasia*, Cambridge: Cambridge University Press, 2001.
- "Sharing out the Empire: Apportioned lands under the Mongols" in Khazanov, A. and Wink, A. (eds.), *Nomads in the Sedentary World*, Richmond: Curzon, 2001, 172-90.
- Commodity and Exchange in the Mongol Empire; A Cultural history of Islamic Textiles*, Cambridge: Cambridge University Press, 1997.
- Aubin, J., *Émirs Mongols et Vizirs Persans dans les Remous de l'Acculturation*, Paris: Association pour l'Avancement des Études Iraniennes, 1995.
- Barthold, V., *Sochinenija*, vol. 2, Moscow: Nauka, 1964.
- Sochinenija*, vol. 5, Moscow: Nauka, 1968.
- Turkestan Down to the Mongol Invasion*, ts. by H. A. R. Gibb, second edn. London: E. J. W. Gibb Memorial Trust, 1958; fourth edn. 1977.
- Bira, Sh., *Mongolian Historical Writings from 1200-1700*, Washington: Western Washington University, 2002.

¹⁵ Melville, C., "The Mongols in Iran," in Komaroff and Carboni (eds.), *The Legacy of Genghis Khan: Courtly Art and Culture in Western Asia, 1256-1353*, London: Yale University Press, 2003 a, 37-61.

¹⁶ Biran, M., *Chinggis Khan*, Oneworld, 2007:95.

- Монголын Түүх Соёл, Түүхийн бичлэгийн Судалгаа, Ts. Ishdorj and Kh. Purevtogtokh (eds.), 3 vols., vol. 3, Ulaanbaatar: Interpress, 2001.
- Biran, M., *Chinggis Khan*, Oneworld, 2007
- The Empire of the Qara Khitai in Eurasian History: between China and the Islamic World*. Cambridge: Cambridge University Press, 2005.
- Qaidu and the Rise of the Independent Mongol State in Central Asia*, Surrey: Curzon, 1997.
- “The battle of Herat (1270): a case of inter-Mongol warfare” in N. Di Cosmo (ed.), *Warfare in Inner Asia (500-1800)*, Leiden: 2002, 175-219.
- Boyle, J., *The Mongol World Empire, 1206-1370*, London: Variorum Reprints, 1977.
- “Some Additional Notes on the Mongolian Names in the *History of the Nation of the Archers*”, *Researches in Altaic Languages*, (1975): 33-42.
- “Some Thoughts on the Sources for the Il-Khanid Period of Persian History”, *Iran XII* (1974): 185-88.
- “Rashid al-Din: The First World Historian”. *Iran IX* (1971): 19-26.
- (ed.), *The Cambridge History of Iran. The Saljuq and Mongol Periods*, 8 vols., vol. 5, Cambridge: Cambridge University Press, 1968.
- Browne, E., *A Literary History of Persia*, Tehran: Sang-e Meel Publications, 1906.
- Grabar, O. “The Visual Arts” in Boyle, J.A., *The Cambridge History of Iran*, v. 5, 1968
- Dalai Ch., Монголын Түүх, 1260-1388. N. Ishjamts (ed.), 3 vols., vol. 3, Ulaanbaatar: Erdem, 1992.
- Juvayni, ‘Ala’ al-Din (623/1225-681/1283), *Tasliyat al-Ikhvan*, ‘Abbās Māhyār (ed.), Tehran: Ābād, 1982.
- Ta’rikh-i Jahān-Gushā*, Mīrzā Muhammad Qazvīnī (ed.), 3 vols., Tehran: Pīk Irān, 1962.
- The History of the World Conqueror*, ts. by J. A. Boyle, Manchester: Manchester University Press, 1997.
- Jūzjānī, Mīnhāj b. Sirāj M. (589/1193- d. after 664/1265), *Ṭabaqāt-i Nāṣirī* (657/1259- 658/1260), tr. by H. G. Raverty, W. N. Lees (ed.), 2 vols., reprint New Delhi: Oriental Books, 1970.
- Ibn al-Athīr (1160-1233), *Al-Kāmil fi’l-ta’rikh*, tr. by P. Juze, Baku: Azerbaijan Institute of History, 1940.
- Ibn Battutah, *The Travels of Ibn Battutah*, tr. by Hamilton Gibb, Tim Mackintosh-Smith (ed.), London: Picador, 2003.
- The King’s Dictionary: the Rasulid Hexaglot-fourteenth century vocabularies in Arabic, Persian, Turkic, Greek, Armenian, and Mongol* translated by Tibor Halasi-Kun ... [et al.]; with introductory essays by Peter B. Golden and Thomas T. Allsen; edited with notes and commentary by Peter B. Golden.
- Lane, G., *Daily life in the Mongol Empire*, London: Greenwood Press, 2006.
- Lewis, B., *The Assassins: A Radical Sect in Islam*, London: Phoenix, 2003.
- Luvsanbaldan, Kh., “Монгол Иракийн бөхийн спортын харилцааны тухай түүхэн мэдээ” in L. Enkbaatar (ed.), *Khaltaryn Luvsanbaldan*, Ulaanbaatar: Admon, 2006, 71-72.
- May, T., *The Mongol Art of War*, South Yorkshire: Pen and Sword Books, 2007.
- “The Mongol Presence and Impact in the Lands of the Eastern Mediterranean” in D. Kagay, and L. Villalon (eds.), *Crusaders, Condottieri, and Cannon*, Leiden, Boston: Brill, 2003.
- Melville, Ch. “Anatolia under the Mongols” in Kate Fleet (ed.), *Cambridge History of Turkey: Byzantium to Turkey, 1071-1453*, vol. 1, Cambridge: Cambridge University Press, 2009, 51-101.
- “The Mongols in Iran” in Komaroff and Carboni (eds.), *The Legacy of Genghis Khan: Courtly Art and Culture in Western Asia, 1256-1353*, London: Yale University Press, 2003, 37-61.
- The Impact of the Mongol invasions on Iran, Iraq and Central Asia: A Revaluation*, The Indo-Mongolian lecture at the New York University, March 12. 1997.
- Nasawī, Shihāb al-Dīn Muḥammad (fl. 1241), *Sīrat al-Sultān Jalāl al-Dīn Mankubirni*, Nasih ‘Ali (ed.), Tehran: Sa’dī, 1366/1987, tr. by Z. M. Bunijatov, Moscow: Vostochnaja Literatura, 1996.
- Sagaster, K., *Die Weisse Geschichte*, Wiesbaden: Harrassowitz, 1976.
- Rashid Al-Din. Faql Allāh (Ca 645/1247-718/1318), *Jāmi’ Al-Tavārikh* (704/1306-710/1311), (Судрын Чуулган), Karīmī (ed.), Tehran: Āqbāl, 1954.